



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/Б

Номгон

Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгогдсон газарт Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэхийг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 35 дугаар зүйлийн 35.1.1. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.1, 28 дугаар зүйлийн 28.1.3, 33 дугаар зүйлийн 33.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2/7 дугаар тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын II Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 2/3 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.1, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.2, 4.1.3, 4.4.20 дахь заалтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор хотын төв хэсэг болон гэр бүлийн хэрэгцээний газарт барилгын материалын үйлдвэрлэл эрхлэхийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хориглосугай.

2.Барилгын материалын үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрлэлийн бүсэд газар ашиглуулах ажлыг зохион байгуулалттайгаар олгож, нүүлгэн шилжүүлэх ажлыг хийж хэрэгжүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3.Хотын төв хэсэг болон гэр бүлийн хэрэгцээний газарт барилгын материалын үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг гарган захирамжийг сурталчилж, хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн биелэлт үр дүнг тооцож, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Засаг даргын Орлогч (С.Батцэрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ЭНХБАЯР

Баянхонгор сумын Засаг даргын 2024 оны
...01... дүгээр сарын 27 -ний өдрийн А.113
дугаар захирамжийн хавсралт



БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЭЛЖ БАЙГАА ИРГЭН
АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БҮСЭД ГАЗАР АШИГЛУУЛАХ
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙГААР ОЛГОЖ, НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ
АЖЛЫГ ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН АЖЛЫН ХЭСГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч

Н.Пүрэвжаргал

(Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тасгийн дарга)

Гишүүд:

Б.Нармандах

(Сумын газрын даамал)

Х.Баасанжаргал

(Сумын газрын даамал)

Б.Ууганзаяа

(Худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан

мэргэжилтэн)

Ц.Баасанбат

(Газар зохион байгуулалт, инженерийн шугам

сүлжээ, зам талбайн асуудал хариуцсан ажилтан)

Ц.Нармандах

(Гэрэлтүүлгийн асуудал хариуцсан ажилтан)

Багийн Засаг дарга нар

П.Баатар

(Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал

хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: